



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААНУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021.06.29

Хуурч

Монгол улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэр, аймаг, сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын албан даалгавар, захирамж шийдвэрийг хэрэгжүүлэх, сумын байгууллага иргэдэд сурталчлах, биелэлтийг тооцон ажиллах, аймгийн ЗДТГ-с зарласан “Хөрөнгө оруулалт-бүтээн байгуулалтын жил”- ийн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа талаар тайлагнаж байна.

**НЭГ. ТӨРИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ТАЛААР:**

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**

Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээг оны эхэнд байгуулан гэрээний дагуу төсөвт байгууллагын удирдлагуудтай төсвийн ерөнхийлөн захирагч үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байна.



2021 оны хагас жилийн байдлаар Сумын Засаг даргын Тамгын газарт хандсан 340 албан тоот ирснийг бүртгэж дор бүрд нь ирсэн бичгийн дэвтэрт хөтөлж хэвшсэн. Үүнээс Монгол Улсын Засгийн газрын тогтоол 12, Аймгийн засаг даргын захирамж 23, Аймгийн Онцгой комиссын тогтоол 3, албан даалгавар, сумын ИТХ-ын тогтоол 13 тус тус ирсэн байна. Сумын Засаг даргын А дугаартай 82, Б дугаартай 9 захирамж, албан тоот 187, Тамгын газрын даргын А дугаартай 26, Б дугаартай 10 тушаал, албан тоот 61, сумын Онцгой комиссын тогтоол 2 тус тус гарсныг холбогдох газруудад болон албан тушаалтнуудад хүргэж, биелэлтэд нь хяналт тавьж ажилласан.

Ирсэн бичгийг ЗДТГ-ын архив, бичиг хэргийн ажилтан бүртгэлийн дэвтэрт бүртгэж Засаг дарга, удирдлагуудаар цохуулан ажилтнуудад тарааж хариутай албан бичгийн хариуг холбогдох албан тушаалтнуудаар гаргуулж холбогдох хаягаар илгээж ажиллалаа.

## 2021 ОНЫ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ШИЛДГҮҮД

Газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан хөдөлмөр зүтгэл, ажлын амжилтаа төр засагтаа үнэлүүлэн "УЛСЫН АВАРГА ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН"-оор Д.Батнасан захиралтай "Шүрэн тариа" ХХК шалгарч, шагналаа гардан авлаа.



### ❖ *Аймгийн аваргууд*

Газар тариалан, Мал аж ахуйн салбарт ажил хөдөлмөрөөрөө манлайлсан сумын 3 иргэн Аймгийн аварга боллоо. "Аймгийн аварга хамт олон"-оор Ц.Сүрэн захиралтай "Бургастайн хишиг" ХХК, "Аймгийн аварга малчин"-аар Оргих 1-р багийн малчин А.Шагдарсүрэн, "Аймгийн аварга механикжуулагч"-аар "Шаргал тариа" ХХК-ийн механикжуулагч Д.Ганбат нар шалгарсныг 01 дүгээр сарын 30-ны өдөр аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Б.Болорзул болон сумын удирдлагууд хүндэтгэл үзүүлэн гардууллаа.



### ❖ *Сумын аваргууд*

01 дүгээр сарын 20-ны өдөр сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлийн шийдвэрээр сумын аваргуудаа тодрууллаа.

"Аварга тариаланч"-аар "Монгол ногоо" ХХК техникч Г.Пүрэвбаатар, "Өгөөж дэлхий" ХХК - ийн техникч Д.Болдбаатар, "Аварга ажилчин"-аар Эрүүл мэндийн төвийн жолооч Б.Бат-Очир, "Ургацын хишиг" ХХК - ийн ажилтан Д.Эрхэмбаатар, "Аварга төрийн албан хаагч" -аар ЕБС-ийн багш Д.Орхонтунгалаг, "Аварга мэргэжилтэн" -ээр Эрүүл мэндийн төвийн сувилагч Б.Цолмон, "Аварга худалдаа үйлчилгээний ажилчин"-аар хувиараа бизнес эрхлэгч Г.Атарсайхан, "Аварга малчин" -аар 1 дүгээр багийн малчин М.Баяржаргал, "Аварга сурагч"-аар ЕБС-ийн 12А ангийн сурагч О.Хулан, 10Б ангийн сурагч Д.Эрдэнэт-Од, 10Б ангийн сурагч Б.Мөнхжин, "Алдарт уяач"-аар 2 дугаар багийн иргэн Х.Сайхан-Эрдэнэ, Д.Сүрэнхүү,

Ц.Амарсанаа , 3 дугаар багийн иргэн Н.Цагаанхүү нар шалгарсныг сумын удирдлагууд хүлээн авч шагналыг гардууллаа.

### **100 НАСТАНДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЖ, ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИЙГ ГАРДУУЛАН ӨГЛӨӨ**

"Буян үйлдэгч" хэмээх усан бар жилийн сар шинийн баярыг тохиолдуулан УИХ-ын гишүүн Ч.Ундрэм, сумын ИТХ-ын дарга Г.Цэндсүрэн нар сумын өндөр настан Гэндэнжавын Долгоржав гуайн гэрт нь очиж хүндэтгэл үзүүлэн амар мэндийг эрэн золгож, Монгол Улсын Ерөнхийлөгчийн гарын бэлгийг гардуулан өглөө.



Мөн уг өдөр Төрийн дээд одон медаль "Алтан гадас" одонгоор сумын 2 дугаар багийн иргэн, Улсын аварга тариаланч Далхаагийн Батбаяр, "Хөдөлмөрийн хүндэт" медалиар "Тариан цацал" ХХК-ий менежер Цэндсүрэнгийн Батболд нар шагнагдсаныг УИХ-ын гишүүн Ч.Ундрэм, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж, сумын удирдлагууд хүндэтгэл үзүүлэн гардуулан өглөө.

### **АЙМГИЙН "ШИЛДЭГ СУМ"-ААР ШАЛГАРЛАА**


"Хүнээ дээдэлж, хамтдаа хөгжье" удирдах ажилтнуудын сургалт зөвлөгөөн 03 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан бөгөөд сумын төр төсвийн байгууллагын удирдлагууд, ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нар оролцлоо. Сургалт зөвлөгөөний үеэр Сэлэнгэ аймаг 2021 оны ажлаараа тэргүүлсэн сум, байгууллага, агентлагийг шалгаруулсан ба Цагааннуур сум 2021 оны ажлын үр дүнгээрээ аймгийн "Тэргүүний сум"-аар шалгарлаа.



Мөн аймгийн Засаг даргын санаачилгаар зохион байгуулагдсан "Тохижилт-ногоон байгууламж аяны хүрээнд сумандаа зохион байгуулсан ажлын бүтээмжээрээ аймгийн "Шилдэг сум" , сумын 2 дугаар цэцэрлэгийн хамт олон шилдэг байгууллагын "Дэд байр" –нд шалгарлаа.

## **МАЛЧДЫН ӨВӨЛЖИЛТИЙН БАЙДАЛТАЙ ТАНИЛЦЛАА.**

02 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвийн ажилтнууд хамтран 8 хэсэг болж 1,3 дугаар багийн 380 малчин өрхөөр явж өвөлжилт хаваржилтын байдалтай танилцан, сумын Засаг даргын Тамгын газраас 2021 онд зохион байгуулсан ажлын тайлан болон цаг үеийн ажлын мэдээлэл хүргэж ажиллалаа.



## **МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНИЙ ТАРХАЛТААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ**

Оргих 1 дүгээр багийн нутаг Цацанд мал, амьтны гоц халдварт шүлхий /A01/ өвчний клиник шинж тэмдэг илэрч, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн шинжилгээгээр батлагдсан тул сумын Засаг даргын А/36 тоот захирамжаар голомтын бүсэд 03 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоож, Мал эмнэлгийн ерөнхий газраас хуваарилагдан ирсэн вакциныг сумын Засаг даргын А/40 тоот захирамжаар эрүүл, хамгаалалтын бүсэд дархлаажуулалтын 11 баг гарган ажлыг шуурхай зохион байгуулан ажиллаж байна.

Мөн дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэхээр 03-р сарын 24-ний өдрөөс 6 сумын малын эмч, тархвар зүйч нар 5 хоног дайчлагдан ажилласан бөгөөд дархлаажуулалтыг сумын Мал эмнэлгийн нэгдлийн 4 малын эмч үргэлжлүүлэн хийж байна. Голомтын бүсэд 2 малын эмч 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 04 дүгээр сарын 5-ны өдөр хүртэл ажиллаж өдөр бүр шинж тэмдгийн үзлэг тандалт хийх, айл хоорондын малыг нийлүүлэхгүй бэлчээхэд хяналт тавин, өвчний шинж тэмдэг илэрсэн өрхийн хашаа хороо, өвөлжөө, өтөг бууцын 8165 мкв талбайг уурын мананцаржуулагчаар халдваргүйтгэж малчдад зөвлөмж, зөвлөгөө өгч, дээд шатны байгууллагыг мэдээ мэдээллээр ханган ажиллалаа.

Дархлаажуулалтад нийт 559 өрхийн 17709 үхэр, 1310 гахай, хонь 16097, ямаа 17859, нийт 52975 толгой мэдрэмтгий мал амьтныг хамруулаад байна. Хорио цээрийн дэглэмийг чандлан сахиулах, тархалтыг зогсоох зорилгоор өвчний бүс нутагт хяналтын 4 цэгт цагдаа, Засаг даргын Тамгын газрын ажилтнууд, төр

төсвийн байгууллагын ажилтнуудын бүрэлдэхүүнтэй пост гарч, зорчих хөдөлгөөнд хориг тавин ажиллалаа.



### **ҮНДСЭН ХУУЛИЙН ӨДӨР**

Сумын Засаг даргын “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/07 тоот захирамжаар батлагдсан төлөвлөгөөний дагуу Ардын Их Хурлын депутат, Монгол Улсын гавьяат Механикжуулагч Нацагийн Дэлгэрмөрөнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид болон Засаг дарга хүндэтгэл үзүүлсэн. Мөн Н.Дэлгэрмөрөнгийн нэрэмжит бүсийн Шатрын аварга шалгаруулах тэмцээнийг 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Тэмцээнд эрэгтэй эмэгтэй нийт 22 тамирчин оролцож оюун ухаанаа сорин өрсөлдлөө.



### **ЦЭРГИЙН ТОО БҮРТГЭЛ**

Аймгийн Засаг даргын 2022 оны А/03 тоот захирамжийн дагуу цэргийн бүртгэлийн 01 дүгээр сарын 07-21-ний өдрүүдэд зохион байгуулж 1, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтний дэлгэрэнгүй бүртгэлийг аймгийн Цэргийн штабт хүргүүлсэн. 2022 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулж 45 цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, 2 иргэн цэргийн албанд татагдсан.

### **ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН ДАДЛАГА СУРГУУЛИЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА**

Аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургууль 06 сарын 3-5-ны өдрүүдэд “Танхимын сургалт”, “Бэлэн байдлын үзлэг”, “Штабын дадлага”, “Дадлага, сургууль” гэсэн үндсэн дөрвөн хэсэгтэйгээр явагдлаа. Штабын дадлага сургууль нь сумын нутаг дэвсгэрт хүчтэй газар хөдлөлт, малын гоц халдварт өвчин болсон үеийн удирдлагын хариу арга хэмжээ, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн анги, албадын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгох, өгөгдсөн цагийн байдлын дагуу бүлгээр ажиллах дадлагаар явагдлаа. “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн

иргэдийг аюулгүй нүүн шилжих дадлага сурууль 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн өглөө 10:00 цагт түр цугларах талбайд, сургуулилтад 689 иргэн хамрагдлаа.



### **ЦЭРЭГ- СПОРТЫН ДӨЛ ТЭМЦЭЭН**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын нэрэмжит сумын аварга шалгаруулах Цэрэг-Спортын "Дөл" тэмцээн 2022 оны 04-р сарын 29-ний өдөр суманд зохион байгуулагдлаа. Тэмцээнд ЕБС-ийн ахлах ангийн 3 бүлгийн сурагчид бэлтгэл сургуулилтаа ханган оролцож өрсөлдөө. Өгөгдсөн даалгаврын гүйцэтгэл, ур чадвараараа С.Мөнхсарнай багштай 11а ангийн "ХАНГАРЬД" баг бусдыгаа манлайлан тэргүүлэн, бүсийн аварга шалгаруулах тэмцээний эрхээр шагнагдлаа.

Мөн Сэлэнгэ бүсийн сумдуудын аварга шалгаруулах Цэрэг-Спортын "Дөл" тэмцээнийг суманд зохион байгуулж, Зүүнбүрэн сумын "Сүлд" түрүүлж, аймгийн аварга шалгаруулах тэмцээний эрхийг гардан авлаа.

Тэмцээнд багууд бэлтгэл, хувцас жигдрэлтдээ ихээхэн анхаарч, ач холбогдол өгч оролцлоо. Тэмцээнийг Асуулт хариулт, Тасгийн гүйцэтгэх ажиллагаа, дасгал, Гүйлтийн тэмцээн гэсэн 3 бүлгийн 14 төрлийн даалгаврын гүйцэтгэлээр үнэлэн явуулсан юм.



### **БАГИЙН ЗАСАГ ДАРГЫН СОНГУУЛЬ БОЛЛОО**

02 дугаар сарын 22, 23, 24-ний өдрүүдэд Оргих 1, Хуурч 2, Тийрэг 3 дугаар багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаан зохион байгуулагдаж багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны дарга сонгох, багийн Засаг даргад нэр дэвшүүлэх үйл ажиллагааг зохион байгууллаа.



## **ИТХ-ЫН НӨХӨН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

Сумын ИТХ-ын нөхөн сонгуулийг 2022 оны 06 дугаар сарын 19-ний өдөр зохион байгууллаа. Сумын 2,3 дугаар багт 3 мандат дээр нөхөн сонгууль явагдлаа. Нөхөн сонгуульд МАН-аас 3 нэр дэвшигч, Ардчилсан намаас 2 нэр дэвшигч, Бие даан 1 иргэн нэр дэвшиж өрсөлдөө.



## **“ТЭРБУМ МОД” ЗӨВЛӨГӨӨНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

2022 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар зохион байгуулагдаж буй "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд сумандаа "Тэрбум мод-Цагааннуур-2022" зөвлөгөөн, үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Зөвлөгөөнөөр "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг Сэлэнгэ бүсэд хэрхэн хэрэгжүүлэх арга зам, оролцоо, тарьц суулгац бэлтгэх, ойжуулалт, мод үржүүлэг, жимс жимсгэний мод тарьж ургуулах техник технологи, усалгаа арчилгааны талаар иргэдэд зөвлөгөө мэдээлэл хүргэлээ. Мөн мод, бут, сөөгний үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.



## **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН УЛСЫН ТООЛЛОГО**

Орон нутгийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого болохтой холбогдуулан явагдсан сургалтад төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч, нягтлан бодогч, эд хариуцагч нийт 18 албан хаагч хамрагдсан.

Улсын үзлэг тооллогод сумын төсвийн 9 байгууллага хамрагдаж, орон нутгийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого хийж, эд хөрөнгийн болон бусад мэдээллийг программд бүрэн оруулж дууслаа. Уг ажлын хүрээнд аймгийн эд хөрөнгийн үзлэг тооллогын ажлын хэсэг суманд ажиллаж, эд хөрөнгийг түүврийн аргаар нүд үзэн чанар, бүрэн бүтэн байдалтай танилцлаа. Тооллогын үеэр гарсан зөрчил дутагдлыг засаж сайжруулах зөвлөгөө зөвлөмж, албан даалгавар өглөө.



### **ХАА-Н ТООЛЛОГО -2022 ОН**

Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/69 тоот захирамжаар ХАА-н тооллого явуулах 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллалаа.

Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй малчин болон мал бүхий, газар тариалан эрхэлдэг давхардсан тоогоор 402 өрх, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг тооллогодоо хамрууллаа. Үүнд:

- Газар тариалан эрхэлдэг өрх-82
- Газар тариалан эрхэлдэг ААНБ-31
- Мал аж ахуй эрхэлдэг өрх -276
- Мал аж ахуй эрхэлдэг ААНБ -11
- Ойн аж ахуй эрхэлдэг өрх -1 тус тус хамрагдсан.





## **ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР**

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн баярын “Хандлагаа өөрчилж, хамтдаа хөгжье” эмэгтэйчүүдийн чуулга уулзалт, “Бүсгүйчүүд” уралдаант тэмцээн зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд Лектор Н.Алтанцоож “Харилцаа” сэдэвт сэтгэл зүйн сургалт, “Охидын дуу хоолой”, “Эмэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудал – шийдэл” хэлэлцүүлэг, шагнал гардуулах ёслол, урлагийн тоглолт боллоо.



## **ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР**

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах баярын өдрийг “Нэгдүгээрт хүүхэд” уриан дор зохион байгууллаа. Уг өдөр хүүхдийн хөгжил танин мэдэхүйд чиглэсэн ажил арга хэмжээнүүд зохион байгуулагдлаа.

Байгууллагууд өөр өөрийн үйл ажиллагааг сурталчилсан бяцхан хотхонуудыг байгуулж, хүүхдүүдэд үйлчилгээ үзүүллээ.

Нэгдүгээр цэцэрлэг "Цэцэгсийн хотхон" байгуулж, хүүхдүүдэд үндэсний өв соёл, уламжлалт тоглоом наадгайг сурталчлан таниулсан бол Хоёрдугаар цэцэрлэг "Тоглоомын хотхон"-доо хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх тоглоом наадгай байршуулж чөлөөтэй тоглож наадах боломжийг олгосон байлаа. Мөн Спорт цогцолборын "Спортын хотхон" -оороо дамжуулан 5-6 настнуудын дунд зохион байгуулахын зэрэгцээ хотхон дахь оюун ухааныг хөгжүүлэгч шатар, даамыг хүүхдүүдэд сурталчлан таниулж ажиллалаа. Соёлын төвөөс сургууль, цэцэрлэг, дугуйлангийнхаа бяцхан авьяастнуудын урлагийн тоглолтыг бэлтгэн хүргэсэн ба "Номын хотхон"-ыг дэлгэн танилцууллаа.



Мөн уг өдөр олон хүүхэд төрүүлж өсгөсөн нийт 14 эхэд “Алдарт эхийн одон” –г гардуулан өгч баяр хүргэхийн зэрэгцээ 28 ихэр хүүхдэд гарын бэлэг гардуулан өглөө.



2021-2022 оны хичээлийн жилд улс, аймгийн чанартай уралдаан тэмцээнд амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулан шагналаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 13 хүүхдэд засаг даргын гарын бэлгийг гардууллаа.



## **СЭЛЭНГЭ БҮСИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН УРЛАГ –СПОРТЫН ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО**

Сэлэнгэ бүсийн Цагааннуур, Түшиг, Зүүнбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд урлагийн 3 номер, спортын 6 төрлийн тэмцээнээр авхаалж самбаа, авьяас чадвараа сорин өрсөлдөж “Тэргүүн байр” эзэллээ.



## **МОД МОДОН МАТЕРИАЛЫН ҮНИЙГ БУУЛГАЛАА**

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 48 дугаар тогтоол болон иргэдээс ирсэн санал, хүсэлтийг хүлээн авч, үүний дагуу сумын удирдлагууд ойн мэргэжлийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулан



мод, модон материалын үнийг тодорхой хувиар буулган тогтоолоо.

1. 15x15см -ийн палк		
Одоогийн үнэ	-	Буулгасан үнэ
40000 төг	-	30000 төг
2. 12x15см-ийн палк		
35000 төг	-	25000 төг
3. Цэвэр банз		
400000төг	-	300000 төг
4. Зах банз		
250000төг	-	200000 төг

## **ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА**

Шаамар сумаас Түшиг сум хүртэлх хатуу хучилттай авто зам тавих “Монгол ЛЗ зам гүүр” ХХК-ий удирдлагатай сумын Засаг дарга хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээний хүрээнд сумын иргэдээс 30 иргэнийг ажлын байраар хангах, сумын 3 дугаар багийн Хонхрын чиглэлд 900 метр сайжруулсан шороон зам, төв замаас “Очир” дэлгүүрийн уулзвар хүртэлх 480 метр хатуу хучилттай авто зам тавих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр тохиролцлоо.

## **ХОТ ХООРОНДЫН НИЙТИЙН ТЭЭВРИЙН АВТОБУС ЯВЖ ЭХЭЛЛЭЭ**

Сумын Засаг дарга “CITY BUS” компаний захиралтай тохиролцсоны үндсэн дээр 03 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн “City bus” ХХК-ий зорчигч тээврийн автобус Цагааннуур - Улаанбаатар чиглэлд 7 хоногийн Пүрэв гарагт явж, Лхагва гарагт сум руу зорчигч тээвэрлэн ирдэг боллоо.



## **АВТОТЭЭВРИЙН УЛСЫН ҮЗЛЭГ-2022**

2022 оны 05-р сарын 25-27 ний өдрүүдэд авто тээврийн улсын үзлэг болж нийт 687 тээврийн хэрэгсэл, үүнээс суудлын автомашин 355, ачааны автомашин 294, зүтгүүр 1, автобус 4, цэстэрн 2, тусгай зориулалтын 2, механизм 8, чиргүүл 4, мотоцикл 17 тус тус хамрагдлаа.



## **ТАНД ТУСЛАХ ЦАХИМ ХӨТӨЧ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**



Иргэний танхимд байгуулсан цахим хөтчийн буланг ашиглан хууль эрх зүйн зөвлөгөөг иргэд өөрсдөө авч болох талаарх мэдээллийг сумын Эрх зүйн 2 хөтөчтэй хамтран нийт 26 иргэнд хүргэсэн. Эхний хагас жилийн байдлаар 1 иргэн Эрх зүйн хөтчийн булан ашигласан. “Төрийн цахим үйлчилгээний операторын нэгдсэн систем”-ээр дамжуулан нийт 16 төрлийн 236 лавлагаа мэдээлэл олголоо.


## **ЗОЛБИН НОХОЙ УСТГАЛЫН АЖИЛ**

2022 оны 04-05 дугаар сард золбин нохой устгалын ажил явагдаж, нийт 130 золбин нохойг устган, хогийн нэгдсэн цэгт хаяж, ариутгал халдваргүйтгэл хийлээ.



## **БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа байгаль хамгаалагч нар хамтран хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлж Ноён уул, Тосонгийн амны чиглэлд хөдөлгөөнт эргүүл шалгалт хийж ажиллаа. Хяналт шалгалтаар суудлын машинаар мод зөөж буй зөрчил илрүүлсэн бөгөөд зөрчлийг цагдаад шилжүүлэн ажиллалаа. Мөн иргэдийн түлээний мод бэлтгэл, эрхийн бичигт хяналт тавин ажиллалаа.



Тамгын хоолой, Баянхангай, Далтын чиглэлд голын эрэг даган хууль бус ан агнуур, загасчлалаас урьдчилан сэргийлэх эргүүл хяналтын ажлыг 1,2 дугаар багийн байгаль хамгаалагч нар хийж гүйцэтгэлээ.



## **БҮХ НИЙТИЙН ХОГ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ӨДӨР**

2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Сумын Засаг даргын А/37 тоот “Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай” захирамжийн дагуу 2021 оны 03 дугаар сарын 24-нөөс 26-ны өдрүүдэд зохион байгуулан ЗДТГ-ын 4 ажилтан албан хаагчид, Хүнсний талонд хамрагддаг 14 иргэд, Худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэд, 9 аж ахуй нэгж байгууллагуудаас 120 иргэн, нийтдээ 160 иргэн хог цэвэрлэгээнд оролцож ойр орчмынхоо 50м болон сумын төв доторх 1,3 км засмал замыг цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт буулгалаа.



## **ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ**

Суманд худалдан борлуулж буй хүнсний аюулгүй байдал, түүхий эд материалын стандартыг хангуулах, хүнсээр дамжих элдэв халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, үүнтэй холбогдолтой хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчлийг арилгах зорилгоор Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 03-05 дугаар сарын хооронд 2 удаа худалдаа үйлчилгээ эрхлэгч, хүнсний үйлдвэрлэл эрхэлж буй төсвийн байгууллагуудад хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар хүнсний чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй, хадгалах хугацаа дууссан 26 нэр төрлийн 328 ширхэг 631250 мян төгрөгийн бүтээгдэхүүнийг лангуунаас татуулж, 65 нэр төрлийн 460 ширхэг бүтээгдэхүүнийг буцаалт хийлгэж, 81 нэр төрлийн 876 ширхэг барааг устгалд орууллаа.



## СУРГАЛТ

Төрийн албан хаагчийг ажлын байранд нь чадавхжуулах, харилцаа, хандлага, ажлын үр дүн, гүйцэтгэл, ур чадварыг нэмэгдүүлэх онол, практик, олон улсын туршлагын шинэ мэдлэг, мэдээллийг түгээх зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 11 удаагийн сургалтад давхардсан тоогоор 42 төрийн албан хаагч цахимаар хамрагдлаа.




### **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТАЛААР:**

#### **Санхүүгийн талаар:**

Төсөвт байгууллагуудын дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө гарган засаг даргаар батлуулсан. 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, бусад ажлын сар, улиралд хийх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

Сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд аймгийн Аудитын байгууллагаар шалгуулж баталгаажуулан “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан ба аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгүүлсэн.

Төсвийн дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөө гарган сумын засаг даргаар батлуулан Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв зэрэг байгууллагуудаар төлөвлөгөөний дагуу анхан шатны баримтуудыг нягтлан бодогч, эд хариуцагч нарын санхүүгийн программтай тулган үзэж хяналт шалгалт хийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа



2022 онд Орон нутгийн хөгжлийн сангийн “Тогтвортой амьжиргаа-3” төсөл олон улсын байгууллагаас суманд олгох дэмжлэг 10595. мян.төг, урамшуулал 26163.5 мян.төг, Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилсан дүн 119879.6 мян.төг нийт 156638.9 мян.төг-ийн төсөв батлагдсан байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 62655,5 мян.төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг шилэн данс болон ил тод байдлын самбарт тогтмол

мэдээллэж, tof.gov.mn цахим хуудасны Орон нутгийн хөгжлийн сангийн программд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ тус бүрээр төлөвлөлтийн мэдээллийг орууллаа.

**Татварын талаар:**

***Татвар төлөгчийн бүртгэл***

А.Татвар төлөгчийн хөдөлгөөний бүртгэлийн мэдээ /хариуцлагын хэлбэрээр/

Төрөл	Хариуцлагын хэлбэр	2022.01.01-ны байдлаар	Нэмэгдсэн	Хасагдсан	2022.06.10-ны байдлаар
ААН	ХХК	77	3		80
	ЗБН	1			1
	ББН	7			7
	Хоршоо	11			11
	Салбар	8			8
Төсөвт болон ТБ	Төрийн бус байгууллага	6			6
	Төсөвт	8			8
<b>Бүгд</b>		<b>118</b>			<b>121</b>

Татвар төлөгч нийт ахуй нэгж, төрийн бус байгууллага болон салбарын хувийн хэргийн баяжилт хийгдлээ.

Тайлангийн ирц: 2021 оны 4-р улирал, 2022 оны 1,2-р улирал 100%, мөн нэмэгдсэн ертгийн албан татварын тайланг сар бүр 15-15 буюу 100% ийн гүйцэтгэлтэй байна.

2022 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар өссөн дүнгээр татварын орлогын төлөвлөгөөний биелэлт:

- Улсын төсөвт 94,532.0 мянган төгрөг оруулахаас 171,228.3 мянган төгрөг буюу 181.1 хувь
- Аймгийн төсөвт 83,899.8 мянган төгрөг оруулахаас 127,775.6 мянган төгрөг буюу 152.3 хувь
- Сумын төсөвт 421,589.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 281,385.9 мянган төгрөг буюу 66.7 хувь

Нийт 600,020.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 580,389.9 мянган төгрөг буюу 96.7 хувиар биелүүллээ.

Урьд оны өрийн барагдуулалт: 2022.06.10-ны байдлаар

Татварын төрөл	2022.01.01-ны байдлаар урьд оны ер	Барагдсан	Барагдалтын хувь	2022.06.10-ний байдлаарх үлдэгдэл
Тайлангаарх	331,372.00	261,298.30	78.85	70,073.7
ХШ-ын				
<b>Дүн</b>	<b>331,372.00</b>	<b>261,298.30</b>	<b>78.85</b>	<b>70,073.7</b>

Тайлант оны ногдлын өрийн барагдуулалт: 2022.06.10-ний байдлаар

Татварын төрөл	Тайлант онд ногдсон	Барагдсан	Барагдалтын хувь	2022.06.10-ний байдлаарх үлдэгдэл
Тайлангаарх	168,618.00	76,228.10	45.21	92,389.9
ХШ-ын				
<b>Дүн</b>	168,618.00	76,228.10	45.21	92,389.9

Нийт өрийн барагдуулалт: 2022.01.01 – 2022.06.10-наар

Татварын төрөл	Өрийн дүн	Барагдсан	Барагдалтын хувь	2022.06.10-ний байдлаарх үлдэгдэл
Тайлангаарх	499,990.0	337,526.4	67.51	162,463.6
ХШ-ын				
<b>Дүн</b>	499,990.0	337,526.4	67.51	162,463.6

#### **Статистикийн талаар:**

Хөдөө аж ахуйн ХАА- 1, 2, 3, 6, 7, 9, 10 мэдээг хуваарийн дагуу статистикийн хэлтэст хүргүүлж байгаад хяналт тавин ажиллаж байна. Улирлын ХО мэдээг сонгогдсон 5 аж ахуй нэгж байгууллагаас, МЭ-1 онлайнаар 4-н мал эмнэлгээс авч аймгийн статистикийн хэлтэст хүргүүлээ.

2021 оны 4-р улирал, 2022 оны 1-р улирлын нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг гаргалаа.

2022 оны 6 сарын байдлаар ААНБ-1, 2 мэдээг 34 аж ахуй нэгжээс, аж үйлдвэрийн мэдээг Хуурчийн сүрэг болон Уранцацал ХХК-аас сар бүр авч хүргүүлээ. Хэрэглээний үнийн мэдээг сар бүр 12 аж ахуйн нэгжээс батлагдсан маягтын дагуу авч программд шивэн файлаар болон цаасаар аймгийн статистикийн хэлтэст хүргүүлээ.

#### **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР:**

#### **НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГЭРЭЛТҮҮЛГИЙН УРСГАЛ ЗАСВАР**

Сумын төвийн гэрэлтүүлгийн засварын ажлыг Аймгийн замын сангийн хөрөнгө болон сумын орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар хийж, 82 гэрлийн толгойг лед гэрлээр сольж, гэмтэлтэй гэрлүүдийг засан, кабель утас агаараар татаж шинэчлэн, нийт 150 гэрлийн засварыг “Авто мастер төв” ХХК хийж хүлээлгэн өглөө. Нийт төсөв: 45 сая төгрөг





### **КАМЕРЖУУЛАЛТ**

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмшлийн зам, талбайд нийт 10 байршилд 16 камерыг "Баяжих ундарга" ХХК 28 сая төгрөгийн төсвөөр хийж гүйцэтгэн хүлээлгэж өглөө.



### **БАЯР НААДМЫН ТАЛБАЙН ЗАСВАР**

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хүчтэй салхинд хийсч эвдэрсэн байсан наадмын талбайн баруун урд корпусын засварыг "Бумт оргил констракшн ХХК" 28 сая төгрөгийн төсвөөр хийж гүйцэтгэлээ.



### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БОХИРЫН ХООЛОЙГ ШИНЭЧЛЭХ АЖИЛ**

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр эрүүл мэндийн төвийн бохирын хоолойг шинэчлэх ажлыг "Хүнх сэрвэн ХХК" 29,7 сая төгрөгийн төсвөөр хийж гүйцэтгэлээ.



### **ЕБС-ИЙН АГААРЖУУЛАЛТЫН ХООЛОЙ**

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар ЕБС-ийн “Б” байрны агааржуулалтын стандарт хоолой суурьлуулах ажлыг “Эйр вектер ХХК” 39,9 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн хүлээлгэж өглөө.



### **БОХИРЫН МАШИНТАЙ БОЛЛОО.**

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар бохир сорох, шахах үйлдэлтэй автомашиныг “Цаст хан хөхий ХХК” 48,2 сая төгрөгөөр нийлүүлж, хүлээлгэн өгснөөр сумын байгууллага, ААН, иргэдэд тулгамдаж байсан боловсон нойлын асуудал шийдэгдэх боломж бүрдлээ..



### **НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТОХИЖИЛТ**

2, 3 дугаар багийг холбосон төв зам дагуу хийгдэх Ногоон байгууламж, тохижилтын ажилд “Сэлэнгэ-Таван хан” ХХК шалгарч ажил 40 хувьтай явагдаж байна. Нийт төсөв: 78 сая төгрөг



## **СПОРТ ЦОГЦОЛБОРЫН ЗАСВАРЫН АЖИЛ**

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Спорт цогцолборын их засварын ажлын тендерийг зарлаж "Дээдсийн жигүүр ХХК" шалгарч гэрээ байгуулан, ажлын явц 40 хувьтай явагдаж байна. Төсөвт өртөг: 300 сая төгрөг



## **ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТОЗАМЫН ҮРГЭЛЖЛЭЛ**

Сумын төвийн 2.53 км авто замын үргэлжлэл 400 метр замыг Аймгийн хөрөнгө оруулалтаар 200 сая төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 100 сая төгрөг, нийт 300 сая төгрөгийн өртөгтэйгөөр "Сэлэнгэ-Есөнэрдэнэ ХХК" гүйцэтгэн хүлээлгэж өглөө. Мөн үргэлжлэл 1,4 км замыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр тендер зарлагдан "Сэлэнгэ-АЗЗА ХХК" шалгаран гэрээ хийгдэн ажил эхлэхэд бэлэн болсон байна. Нийт төсөв 914,236,621 төгрөг



## **320 ХҮҮХДИЙН СУУДАЛТАЙ СУРГУУЛИЙН ӨРГӨТГӨЛИЙН БАРИЛГА**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 320 хүүхдийн багтаамжтай өргөтгөлийн барилгын ажлыг хийхээр 4,1 тэр бум төгрөг суулган батлуулсан ба гүйцэтгэгчээр "Асудконстракшн ХХК" шалгарсан. Гүйцэтгэгч компани дулаан, цэврийн шугам татах ажлыг эхлүүлээд байна.



## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ӨРГӨТГӨЛ**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн төвд 15 ортой өргөтгөлийн барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр 507 сая төгрөг суулгуулан батлуулсан ба гүйцэтгэгчээр "Девсофт ХХК" шалгаран ажлаа эхлүүлээд байна.

## **ГЭР ЧУЛУУНЫ ДАВААНЫ ЗАСВАРЫН АЖИЛ**

Гэр чулууны давааны авто замыг сайжруулж, 900 м дайрган хучилттай автозам тавих ажлын тендерийг зарлаж "Сэлэнгэ АЗЗА ХХК" шалгарч гэрээ байгуулсан ажил эхлэхэд бэлэн болсон байна. Нийт төсөв: 175,317,723 төгрөг

## **УУРЫН ЗУУХНЫ БАРИЛГЫН АЖИЛ**

Сумын дулаан, халаалтын үйл ажиллагааг "Эл Си Би ХХК" гэрээгээр хариуцан ажиллаж байгаа бөгөөд олон жил шийдэгдэхгүй байгаа халаалтын үйл ажиллагааны доголдлыг арилгах зорилгоор Шинээр дулааны төвийн барилгын ажлыг эхлүүлээд байна. Мөн энэ шинэчлэлийн хүрээнд орчин үеийн сайжруулсан 2 ширхэг зуух, тогоо суурилуулаад байна.



## **МАА, ГАЗАР ТАРИАЛАН**

### **Газар тариалангийн чиглэлээр**

2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Цагааннуур суманд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч ААНБ, иргэдийн зөвлөгөөнийг зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд тариалан эрхлэгч 8 ААНБ, 6 тариалан эрхлэгч иргэд оролцлоо.

Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан 150 км хашааг ААНБ, иргэдэд хуваарилах ажлыг Атар трейд ХХК-ий захирал, Сэлэнгэ тариа ХХК-ий захирал, Газрын даамал нартай хамтран гүйцэтгэлээ.

Засгийн газраас Хүнсний ногооны тариалан эрхлэгчдэд 80 хувийн хөнгөлөлттэй үнээр олгодог ногооны үрийг 05 дугаар сарын 16-ны өдөр нийт 31 ногоочдод худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

### **Мал аж ахуй, үйлдвэрлэлийн чиглэлээр**

"Газар тариалангийн бүсэд МАА эрхлэгчдэд батламж олгох журам"-ын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэн сумын ИТХ-аар оруулж батлууллаа.

Газар тариалангийн бүсэд үржүүлж буй мал сүрэгт үзлэг ангилалт хийх, ашиг шимийн үзүүлэлтийг тогтоох, цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах, ээмэгжүүлэх,



бүртгэлжүүлэх ажлын шинжээч мал зүйч , ангилагч мал зүйч, бүртгэлийн ажилтан, мал баригч, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй, сумдын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн гишүүдтэй хамтран ажиллалаа.

Үйл ажиллагааны хүрээнд 32 өрхийн 120 адуу, 1823 үхэр, 4862 хонь, 2073 ямаа, нийт 8878 малд үзлэг хийж, 9 адуу, 960 үхэр, 831 хонь, 188 ямаа, нийт 1988 малын үндсэн үзүүлэлтүүд болох сэрвээ, хондлойн өндөр, биеийн ташуу урт, шилбэний бүслүүр, бүсэлхийн тойрог, цээжний гүн, өргөн, амьдын жингийн хэмжээг авч, ялган тэмдэглэгээ хийн, “Мал аж ахуйн нэгдсэн систем”-д шивэн баталгаажууллаа.

### **Жижиг дүнд үйлдвэрлэл, сум хөгжүүлэх сангийн чиглэлээр**

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 50 дугаар тогтоолоор Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулах чиглэлийг батлуулсан. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор:

- Арьс шир, ноос ноолуур боловсруулах
- Мал үржлийн технологийн ажил үйлчилгээний нэгжийг дэмжих
- Мал нядалгааны цех байгуулахад дэмжлэг үзүүлэх
- Нарийн боовны цехийн өргөтгөлд дэмжлэг үзүүлэх
- Авто угаалга, засварын газар шинээр барих болон өргөтгөх чиглэлээр зээл олгохоор боллоо.

Эхний хагас жилд Сум хөгжүүлэх сангийн 24,178,511 төгрөгийн төлөлт хийгдсэн ба муу зээлийн ангилалд 3 иргэний зээлийг шилжүүлээд байна.

### **Мал эмнэлэгийн чиглэлээр**

**Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд:**

**Шөвөг яр** өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд нийт 48200 толгой хурга ишиг хамруулахаас 48200 толгой хамруулж цахим системд гүйцэтгэл оруулсан.

**Боом** өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд нийт 13800 толгой бод, 22800 бог хамруулахаас бод10000, бог 18000,

**Дуут хавдар** нийт 8800 толгой үхэр хамруулах төлөвлөлтэйгээс 4800 толгой үхэр,

**Галзуу** өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 3800-бод, 600-нохой хамруулахаас 2500 толгой үхэр, 300 нохой тус тус хамруулаад байна.

**Үхрийн арьс товруутах** өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 2022 оны 05 дүгээр сарын 12-ны өдрөөс 05 дүгээр сарын 22-ны өдөр хүртэл 24400 толгой үхэр тарьж дуусгалаа. Сумын хэмжээнд нийт 428 малчин, мал бүхий өрх, ААН-ийн 24400 толгой үхэр хамруулж мал эмнэлгийн цахим системд төлөвлөгөө гүйцэтгэлийг бүрэн орууллаа.

**Халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

Хагас жилийн байдлаар нийт 44 удаагийн дуудлага ирсэн ба ихэвчлэн бод малын хаг саатах, сав урвах, нялх төл чацга алдах, бодис солилцоо, эндэмик, эрдсийн дутагдалд орсон мал, амьтан их хорогдсон шалтгаан ургамлын хордлого их байлаа.

Өвчний нэр	Мал амьтны тоо		
	Өвчилсөн	Үхсэн	Эдгэрсэн
А	1	2	3
Тэжээл боловсруулах эрхтний	12	1	11
Амьсгалын замын эрхтний	12	3	9
Зүрх, судас мэдрэлийн системийн	0	0	0
Шээс бэлэг, үржлийн эрхтний	9	0	9
Бодис солилцооны	95	26	69
Эндемик /нэрээр/	50	22	28
Элдэв хордлого	79	31	48
Гэмтэл, бэртэл	0	0	0
<b>ДҮН</b>	<b>249</b>	<b>83</b>	<b>166</b>

### Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх 2022 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн. Угаалга-136100, туулгалт-116846, боловсруулалт-95280 толгой мал, амьтан, Гуурын боловсруулалтанд-14500 толгой үхэр, нохой, муурны үржил таслах арга хэмжээнд 20, нийт 362746 толгой мал, амьтан шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Арга, хэмжээний нэр	Эмийн бодис		Мал амьтны төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	Нэр	Зарцуулсан хэмжээ, (л)				
боловсруулалт	Ивомик	40,75	үхэр	15000	8150	54%
боловсруулалт	Ивомик	30,34	хонь	46000	30340	65%
боловсруулалт	Экотраз	18,6	ямаа	33000	18600	56%
боловсруулалт	Экотраз	0,3	Нохой	600	300	50%
боловсруулалт	Экотраз	0,68	Гахай	680	340	50%
боловсруулалт/Гуур/	Экотраз	24	үхэр	14500	8000	55%
<b>дүн</b>				<b>109780</b>	<b>65730</b>	<b>63%</b>

Арга, хэмжээний нэр	Эмийн бодис		Мал амьтны төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	Нэр	Зарцуулсан хэмжээ, (л)				
туулгалт	Албендазол	120,00	адуу	2050	1200	58%
туулгалт	Албендазол	58,00	Үхэр	10800	5800	53%
туулгалт	Албендазол	139,5	хонь	58000	27900	48%
туулгалт	Албендазол	105	ямаа	41000	21000	51%
туулгалт	Албендазол	8,5	гахай	3200	1700	53%
туулгалт	Арколин	1420	нохой	2800	1420	50%
<b>дүн</b>				<b>117850</b>	<b>59020</b>	<b>52%</b>

Арга, хэмжээний нэр	Эмийн бодис		Мал амьтны төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	Нэр	Зарцуулсан хэмжээ, (л)				
Угаалга	Керолин	2	үхэр	11300	1500	13%
угаалга	Керолин	1	хонь	68000	2200	3%
угаалга	Керолин	1	ямаа	56000	1800	3%
угаалга	Керолин	0,2	Гахай	800	150	18%
Дүн				<b>136100</b>	<b>5650</b>	<b>9%</b>

### **Ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ**

Хагас жилийн байдлаар сумын хэмжээнд 4 МЭҮН-ийн эмч нар түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах цэг, зоорь, тэжээлийн агуулах 4720 м2, малын хашаа, хороо, мал амьтны тоног хэрэгсэл 98505 м2, худаг уст цэг 260 м2, голомтын бүсийн талбай 19695 м2, устгалын цэгийн талбай 5000 м2, нийт 123180 м2 талбайд Нисор-50кг, Superkill-10кг, Рикоцит-5кг тус тус зарцуулж халваргүйтгэл хийлээ.

### **ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**

2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан газруудыг кадастрын байгууллагаар зураг хийлгэн батлуулж, төлөвлөгөөг аймгийн газрын албаар хянуулан батлууллаа.

Мөн газар эзэмших эрх шилжүүлэх хүсэлтээ гаргасан 3 иргэний 80 га газрын газар эзэмших эрхийг шилжүүлж Засаг даргын захирамж шийдвэр гаргаж мэдээллийн санд бүртгэсэн.

Цагааннуур сумын Тийрэг 3-р багийн иргэдийн зуслан Моностой, Гурт, Улаалзганат гэх газруудын Түшиг сумтай хиллэх хилийн маргааныг Сэлэнгэ аймгийн газрын албаныхантай хамтран эцэслэн шийдвэрлэлээ.

Суманд Аймгийн Онцгой байдлын алба байгуулагдахтай холбогдуулан Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төрийн байгууллагын зориулалттай 4000 м2, дулаан үйлдвэрлэл, дулаан түгээх зориулалтаар 3611 м2 газарт хэмжилт хийлгэж 15 жилийн хугацаатайгаар, өвөлжөөний зориулалтаар 3 иргэнд өвөлжөөний нийт 2100 м2 эзэмшүүлэхээр олголоо.

Мөн 6 аж ахуйн нэгж, 4 иргэний нийт 25 нэгж талбарыг газрын мэдээллийн цахим сангийн барьцаа бүртгэлд бүртгэж баталгаажууллаа.

32 иргэний хашаа байшингийн газарт, төрийн байгууллагын 12 нэгж талбарт мэргэжлийн байгууллагаар кадастр хийлгэж баталгаажууллаа.

### **БАЙГАЛЬ ОРЧИН:**

Мод бэлтгэлийн мэргэжлийн байгууллага болох “Бүтээлийн нуур” ХХК, “Шинэбадрах” ХХК-ий доод агуулахад байгаа өмнөх оны үлдэгдэл мод, модон материалыг БОХУБайцаагч, байгаль хамгаалагч, СДОАнгийн инженертэй хамтран тоолж гүйцэтгэлээ.

### **Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил**

Түймрийн хуурайшилттай үед багийн Засаг даргатай хамтран Оргих багийн Баруун гол, Хуурай хөндий, Нянгай, Дунд даваа, Оргих, Согооч, Дээд доод хоолой, Цог өндөр, 6,7-р бригадын ойр орчмын нийт 251 малчин өрхийн 576 иргэн, 2 ААНБ-д Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, түлээний мод бэлтгэхэд анхаарах зүйлс, Ойн дагалт баялаг, жимс жимсгэний тухай, Ан амьтны тухай хууль багтаасан санамжийг тараан танилцуулж, ой хээрийн болон объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх, үнс нурмаа ил задгай асгахгүй байх, зориулалтын тагтай төмөр савыг байршуулахыг сануулж, насанд хүрээгүй хүүхдийг түймрийн аюултай үед чүдэнз, асаагууртай явуулахгүй байхыг анхааруулж, гарын үсгийн баталгаа авч ажиллалаа.



### **Бүх нийтээр мод тарих өдөр**

Бүх нийтээр мод тарих өдөр 3-р багт байрлах Атар-50, үнээ фермийн ард байрлах ногоон байгууламжуудад байгаль хамгаалагч,Тохижилт үйлчилгээний ажилтантай хамтран 15 мод нөхөн тарьж суулгалаа.



Мод тарих тохиромжтой үе, модны тогоог хэрхэн бэлтгэх, хөрсний найрлага, усалгаа зэрэг мэдээллүүдийг багтаасан гарын авлага бэлтгэн “Тэрбум мод Цагааннуур суманд” зөвлөгөөнөөр модны тарьц авсан 35 иргэн, 2 нөхөрлөлд хүргэлээ.



Мод бэлтгэлийн мэргэжлийн байгууллага болох “Бүтээлийн нуур” ХХК, “Шинэ бадрах” ХХК-ий фермийн урд зам дагуулан 4 хэсэг ногоон байгууламжийн хашаанд 150 ширхэг нарс модыг зорилтот бүлгийн иргэдтэй хамтран гүйцэтгэлээ.



**Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх**

Шинэбадрах ХХК-ий Гүн шүрэнд 20 га талбайд шинэс модны ойжуулалт, Бүтээлийн нуур ХХК-ий хариуцсан багийн Сангалтай гэх газар хийсэн шинэс модны 20 га ойжуулсан талбайг сум дундыг ойн ангитай хамтран гүйцэтгэлийг шалгалаа.



06 дугаар сарын 17-30-ны хооронд сумын Засаг даргын А/85 тоот захирамжийн дагуу Шүрэнгийн адаг, Мойлт нуга, Баян нуга, Эрээн хайлааст, Дээд доод хоолой, Бургасан ой зэрэг газруудад ойн хортон шавжтай тэмцэх тэмцлийн ажлыг 1000 га талбайд химийн хор цацаж гүйцэтгэлээ.



## ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ТАЛААР

### Нийгмийн даатгалын үйлчилгээ

2022 оны эхний хагас жилийн байдлаар 739295,78 мян төгрөгөөр шимтгэл төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 42 аж ахуйн нэгж байгууллага, 192 сайн дурын даатгуулагчаас 726216,0 мянган төгрөг бүрдүүлээ.

Эрүүл мэндийн даатгалын санд 241227,5 мянган төгрөгийн шимтгэл төвлөрүүлэхээс 161202,2 мян төгрөгийн орлого хуримтлууллаа.

Хуримтлагдсан өртэй аж ахуй нэгж байгууллагуудын 2022 оны эхний хагас жилд 270705,6 мянган төгрөгийн 30 хувийг барагдуулахаас 13 аж ахуйн нэгж байгууллагын 179576,2 мян төгрөгийн авлагыг 66,3 хувиар барагдуулж 38,3 хувиар өр авлагыг бууруулсан.

2022 оны эхний хагас жилд 2 аж ахуйн нэгж байгууллага нийгмийн даатгалд хамруулахаас 1 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулсан.

2022 оны эхний хагас жилд ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн 5 даатгуулагч хамруулахаас 26 иргэн сайн дурын даатгалд, 13 малчин даатгуулагч хамруулахаас 16 малчныг сайн дурын даатгалд тус тус хамруулаад байна.

ХЧТАлдсан тэтгэмж 68 даатгуулагчид 13196,9 мян төгрөг, Жирэмсэн амаржсан 29 эхэд 42084,8 мян төгрөг, оршуулгын тэтгэмж 6 даатгуулагчид 6000,0 мян төгрөг, ажилгүйдлийн тэтгэмж 16 иргэнд 16666,8 мян төгрөгийг тус тус олголоо.

2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд хөдөлмөр халамжийн үйлчилгээ, сумын Эрүүл мэндийн төв, “Урианхай Шүрэн Уул” ХХК-тай хамтран нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмж болон нийгмийн даатгалын хөнгөлөлт чөлөөлөлт бусад хуулийг нийгмийн даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 36 иргэнд танилцуулж, мэдээ мэдээлэл өгч ажиллалаа.



### Нийгмийн халамжийн ажлын хүрээнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 102 иргэний 197.297.7 мянган төгрөг
- Асаргааны тэтгэмжид 84 иргэнд 40687.3 мянган төгрөг
- Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 4 иргэнд 4800.0 мянган төгрөг
- Эхийн алдар одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламжид 444 иргэнд 58000.0 мянган төгрөг
- Ахмад настанд олгох дэмжлэг тусламжид 22-аас доошгүй иргэнд 2200.0 мянган төгрөг

- Алдар цолтон ахмад настанд олгох хөнгөлөлтөд 8-аас доошгүй иргэнд 7000.0 мянган төгрөг
- Хүндэт донорт олгох хөнгөлөлтөд 1-ээс доошгүй иргэнд 400.0 мянган төгрөг
- Насны хишиг тэтгэмжид 170-аас доошгүй иргэнд 13450.0 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжид 6 иргэнд 950.0 мянган төгрөг
- Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмжид 18 иргэнд 7084.0 мянган төгрөг
- Хүүхдийн мөнгөн хуримтлалд 2500-аас доошгүй хүүхдэд 1.133.200.00 мянган төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 34 өрхийн том хүн 83, хүүхэд 102 нийт 185 иргэнд 12944.0 мянган төгрөг олгоод байна.

**Хөдөлмөр аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**

2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр “Аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлье” уриан дор зохион байгуулагдаж буй “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2022” арга хэмжээний хүрээнд сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуйн нэгж, байгууллагад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа талаар хяналт шалгалт хийж, зөвлөн тусалж ажиллалаа.



"MS development consulting" ХХК , Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран сумын зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор "Хөдөлмөрт бэлтгэх сургалт"-ыг зохион байгууллаа





## **БОЛОВСРОЛ, СОЁЛ, СПОРТ, ЭРҮҮЛ МЭНД, ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:**

### ***Эрүүл мэнд***

Эрүүл мэндийн төв нь ЭМС-ын 2019 оны А/540 тоот тушаалын дагуу хүн амын тоо ш, үйлчлэх хүрээний радиусаас хамааран Б зэрэглэлийн ангиллын дагуу 24 орон тоотойгоор ажиллаж байна. Үүнд: их эмч 3, эх баригч бага эмч 1, бага эмч 1, статистикч бага эмч 1, НЭМ-ийн ажилтан 1, эмийн бус эмчилгээний сувилагч 1, дархлаажуулалтын сувилагч 1, ээлжийн сувилагч 4, лаборант 1, эмийн санч 1, нягтлан бодогч 1, нярав 1, үйлчлэгч 4, тогооч 1, жолооч 2, бүгд 24 ажилтантайгаар сумын хүн амд эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлж байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар амбулаторийн үзлэг 3871, урьдчилан сэргийлэх үзлэг 814, идэвхтэй хяналтыг 441, гэрийн эргэлтийг 44 хүнд хийж үйлчиллээ. Түргэн тусламжийн 1026 дуудлагад хүрч үйлчилснээс алсын дуудлага 1109, осол гэмтлийн дуудлага 16 эзэлж байна.

1 болон 2 дугаар цэцэрлэгийн 275 хүүхэд, ЕБС-ийн 1050 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийлээ.

06 сараас 5 хүртэлх насны 705 хүүхдэд 5,10-р сард А амин дэмийн тараалт хийж бүртгэл хөтөллөө. 0-2 хүртэлх насны 160 хүүхдийг товлолын дагуу дархлаажуулалтад бүрэн хамрууллаа.

### ***Лабораторийн үйл ажиллагааны талаар:***

Эрүүл мэндийн төвийн лабораторид ЦДШ, ШЕШ, Биохими /АЛАТ, АСАТ, Амилаза, Уураг, Глюкоз, Холестрин, Албумин, ШФ, Мочевин, Кератинин, Билирубин/ Шимэгч хорхойн өндөг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ HIV, Syphilis, HCV HBsAg өлөн үеийн Сахар, ASLO, CR, RF, Хеликобактери шинжилгээнүүд хийгддэг. 2022 оны эхний хагас жилийн байдлаар:

- Шээсний ерөнхий шинжилгээг нийт 617
- Цусны ерөнхий шинжилгээг-170
- Цусны дэлгэрэнгүй шинжилгээ/бүх үзүүлэлтээр-124
- Элэгний HCV, HBsAg вирус нийт-119
- БЗДХ, ДОХ/HIV Syphilis/: Нийт- 96
- Хеликобактерийн шинжилгээг нийт 37
- Цусны бүлэг нийт 15
- АЛАТ, АСАТ-123
- Холестрин- 10
- Нийт уураг-123
- Мочевин, Кератинин- 55
- Альфа амилаза нийт-123 иргэнд шинжилгээ хийгдсэн.

2022 оны эхний хагас жилийн байдлаар хачигт халдварын вакцины 1-р тунг 39 хүнд, 2-р тунг 11 хүнд, сэргээх тунг 13 хүнд, нийт 63 хүнд, галзуугийн вакциныг 4 хүнд 10 хүн тун, сайн дурын В гепатитын вакциныг 1-р тун 50 хүнд, 2-р тун 36 хүнд, Ковидын халдвараас сэргийлэх дархлаажуулалтад 1-р тун 38, 2-р тун 14, 3-р тун 86, 4-р тун 322 хүнийг тус тус хамрууллаа.

### ***Спорт***

Аймгийн аварга шалгаруулах Техник-Спортын тэмцээн 2022 оны 05 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Цагааннуур суманд зохион байгуулагдлаа. Нийт авто загвар, нисэх загварын 6 төрөлд 120-иод оролцогчид оюун ухаан авьяас чадвараа сорин өрсөлдлөө.



### **Сумын аварга шалгаруулах спортын тэмцээнүүд зохион байгуулагдлаа**

Улсын ургацын 2 удаагийн аварга "Сэлэнгэ тариа" ХХК-ийн нэрэмжит сумын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн тэмцээнд эрэгтэй 9 баг, эмэгтэй 6 баг өрсөлдөж, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Тэмцээнд хурд хүч, ур чадвараараа бусдыгаа манлайлан оролцсон тамирчдаас эрэгтэй, эмэгтэй төрөлд тус бүр нэг "Шилдэг довтлогч", "Тэгш тоглогч" шалгарууллаа.



Улсын ургацын 7 удаагийн аварга "Товхонхан" ХХК-ийн нэрэмжит сумын аварга шалгаруулах волейболын тэмцээн 03-р сарын 12-13-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд эрэгтэй 7 баг, эмэгтэй 11 баг тамирчид оролцлоо.



### **“Илүүдэл жингүй-Эртэч Монгол аян”**

БТСУХ-ны даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/26 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт “Илүүдэл жингүй–Эртэч Монгол” идэвхтэй хөдөлгөөний аяныг зохион байгууллаа.

Уг арга хэмжээ 2022 оны 02 дугаар сарын 16 –ны өдрөөс 05 дугаар сарын 28-ныг хүртэл явагдлаа. Улсын хэмжээнд өглөөний дасгалыг нэгдсэн журмаар ажлын өдрүүдэд 06:30-07:30 цагт “MAXHUB” самбарыг ашиглан цахимаар зохион байгуулж, аяны хүрээнд илүүдэл жин, таргалалтад нөлөөлж байгаа хүний буруу зан үйл, амьдрах, ажиллах хэв маягийг өөрчлөх, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл мэнд, зөв хооллолт, дасгал хөдөлгөөний зөвлөмжийг тогтмол өгөх, сурталчлах, жишиг төвтэй болох судалгаа хийж, иргэд байгууллагуудад сурталчилж хамтран ажиллалаа. 2022 оны 02 сарын 16-наас эхлэн манай сум ард иргэд болон байгууллагууд маш идэвхтэй хамрагдаж, аяны хүрээнд 06:30-07:30 цагийн хооронд иргэдэд заал, теннис, фитнесийн тоног төхөөрөмжөөр үнэ төлбөргүй үйлчилж байгаатай холбогдуулан манай сумын иргэд 2022 оны 02 дугаар сарын 16 наас эхлэн аянд нэгдэн өдөр бүр иргэдийн тоо нэмэгдэн, сумын ахмад настан, төр төсвийн байгууллагын албан хаагчид, иргэд идэвхтэй хамрагдлаа.



Сэлэнгэ аймагт зохион явагдах “Сэлэнгэ Марафон 2022” тэмцээнийг сумандаа нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэн сурталчлах, иргэдийг чийрэгжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулан хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих зорилгоор 12-13, 14-15, 16-17, 18-35 насны ангиллаар зохион байгууллаа.



Байгууллагаас явуулж буй теннисний дугуйланд 9-12 дугаар ангийн 30 хүүхэд, 1-7 дугаар ангийн 35 хүүхэд, волейболын төрөлжсөн болон энгийн дугуйланд 7-12 дугаар ангийн 15 хүүхэд тогтмол хамрагдан хичээллэж байна. Мөн шатрын дугуйланд бага ангийн сурагчдыг хамруулж байна.

### **Гэр бүл, хүүхэд, залуучууд**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас “NEW STORY” хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, Залуучуудын хөгжлийн зөвлөл, Залуучуудын элч нарыг идэвхжүүлэх, чадавжуулах сургалтад сумын Залуучуудын салбар зөвлөлийн гишүүд болон залуучуудын элчийг хамрууллаа.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн анхдугаар зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан бөгөөд тус сумаас сургууль цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг хамруулж ажиллалаа. Архины хамааралтай өрх толгойлсон 1 эмэгтэйг архины хамаарлаас гаргах эмчилгээнд явууллаа. Уг иргэнийг архины хамаарлаас гаргах, дуршил бууруулах, архины эсрэг үйлчилгээ үзүүлэх суулгацыг /Спираль/ суулгалаа. Мөн 2 сарын хугацаатай 3 удаагийн давтамжтай уух дуршил бууруулах эмийг үйлчлүүлэгчид өгч, сар бүрийн хүнсний талонд хамрууллаа.

### **Боловсрол**

Аймгийн засаг даргын 2022.02.09-ний өдрийн А/47 тоот захирамжийн дагуу “Дэлгэцийн донтолтоос сэргийлж, эрүүл мэндээ хамгаалцаа” болзолт уралдаанд манай сумын 1, 2 дугаар цэцэрлэг болон ЕБС-ийн хамт олон амжилттай оролцсоноор 2 дугаар цэцэрлэг аймагт тэргүүн байр, 1 дүгээр цэцэрлэг “Дэд байр”-д шалгарлаа.



### **СӨБ-ЫН ЧИГЛЭЛЭЭР**

#### **1-р цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар:**

2021-2022 оны хичээлийн жилийн хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээнд 172 хүүхдийг хамруулж нас бүрээр нэгтгэн гаргалаа.



Тус цэцэрлэгийн хамт олон нь ISO 14001 стандартад суурилсан олон улсын Эко- сургууль цэцэрлэг хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, аймаг нийслэлийн ногоон хөгжилд суурилсан хэтийн зорилт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах , ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролын хүрээнд зохион байгуулагдсан ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ НОГООН ОРЧИН-2022 үндэсний VI чуулганд амжилттай оролцож “Хүрэл гэрэгэ” өргөмжлөлөөр шагнагдлаа.



Сургалтын хөтөлбөрийн агуулгыг хүүхдэд хүргэх үйл ажиллагаагаа улам чанаржуулах, хүүхэд өөрөө үйлийн эзэн байж хөдөлмөрийн энгийн дадалд суралцах боломжит орчинг бүрдүүлэх зорилгоор хүүхдийн нас бие хөгжлийн онцлогт тохирсон тавилга хэрэгсэл бүхий “Би өөрөө” төвийг шинээр байгууллаа. Хүүхдүүд энэ төвдөө багштайгаа хамтран тоглох явцдаа хамрын алчуур, оймсоо угаах, товчоо хадах, өндөг чанах, шарах, гурил зуурах , элдэх, алх хадаас хадах ,энгийн туршилт хийх зэрэг бүхий л ажиллагааг өөрөө хийж суралцах боломжтой болсон.



Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/47 тоот захирамж, Сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/20 тоот захирамжийн дагуу “Дэлгэцийн донтолтоос сэргийлж эрүүл мэндээ хамгаалцгаая” аяныг өрнүүлж , аяны хүрээнд хийх ажлуудыг төлөвлөн төлөвлөгөө





гаргаж удирдамж боловсруулан шат дараатай арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа.

“Хүүхдээ сонсьё” арга хэмжээг ахлах бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн дунд амжилттай зохион байгуулж тэдний санал бодлыг сонслоо.



## **2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар:**

Тус цэцэрлэгийн хамран сургах тойрогт нийт 333 хүүхэд хамрагдахаас цэцэрлэгт үндсэн сургалтаар 255 хүүхэд, хувилбарт буюу “Нүүдлийн бүлэг”-т 60 хүүхэд хамрагдаж хамран сургалт 76,5 %-тай байна. Үүнд:

- Бага бүлэг -46
- Дунд бүлэг- 42
- Ахлах бүлэг -50
- Бэлтгэл бүлэг - 58 хүүхэд өдрийн бүлгээр
- Нүүдлийн 2 бүлэгт -60

Анги дүүргэлт буюу нэг багшид оногдох хүүхдийн тоо дунджаар 32.6 байна. Түүнчлэн цэцэрлэгт хамрагдаж чадаагүй үлдсэн хүүхдүүдэд СӨБ-ын үйлчилгээг хүргэх үүднээс Шүрэнгийн голд 2 гэр цэцэрлэгийг Нүүдлийн хэлбэрээр ажиллуулж байна.

Сургалтын чанарт ахиц гарч хичээлийн жилийн ахицын үнэлгээ цэцэрлэгийн хэмжээнд 87,5% -тай гарсан.

2021-2022 оны Хичээлийн жилд Бэлтгэл бүлгийг төгсөх, сургуульд элсэх 58 хүүхдийг Сургуулийн Өмнөх боловсролыг олгож, амжилттай төгссөн.



Мэргэжлийн багшийн хангалт 100%-тай, бүлгийн багш - 6, биеийн тамирын багш – 1 нийт 7 багш ажиллаж байна.

“ Шударга –Удирдагч, Шударга –Төрийн албан хаагч “аяны хүрээнд цэцэрлэгийн эрхлэгч “Багшийн ёс зүй ухамсар сэтгэлгээг өөрчлөх” сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдөр багш туслах багш нарт зохион байгууллаа. Мөн “Байгууллагын соёл-ээрэг хандлага” сэдвээр сургалт нийт ажилчдад зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулан явуулж буй “Дэлгэцийн донтолтоос сэргийлж, эрүүл мэндээ



хамгаалцгаая” аяныг өрнүүлж, эцэг эх, хүүхэд багачуудын дунд “Гар утас хүүхэд аргадах тоглоом биш” сэдэвт сургалт, “Асуудалд шийдэл бий кофетой” хэлэлцүүлэг ярилцлага хийхийн зэрэгцээ “Спортлог гэр бүл” өдөрлөгийг бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгийн эцэг эхчүүдийн дунд, спортын 3 төрлөөр амжилттай зохион байгуулан явууллаа. “Дэлгэцийн донтолт”-ыг илрүүлэх судалгааг цэцэрлэгийн нийт эцэг эхээс 2 удаа авсан ба судалгаанд 6 бүлгийн 158 эцэг эх хамрагдлаа.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг болон НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилтэйгээр хэрэгжиж буй “КОВИД-19-ийн халдвараас урьдчилан сэргийлэхэд эцэг эхийн оролцоо, дэмжлэг” сэдвээр сургагч багш бэлтгэх 4 цагийн цахим сургалтын хүрээнд зарлагдсан бичил төслийн уралдаанд Улсын хэмжээнд 35 ерөнхий боловсролын сургууль, 35 цэцэрлэгийн нэгээр шалгарч улсын хэмжээнд амжилт үзүүлэн ажиллаж байна. Төсөл амжилттай хэрэгжиж аймагтаа “Дэд байр” эзэллээ.

### **ЕБС-ийн үйл ажиллагааны талаар:**

#### **Сургалтын талаар:**

2021-2022 оны хичээлийн жилд “Хүүхэд бүрийн сурч төлөвших нөхцөлийг бүрдүүлж багш бүрийг хөгжүүлэхэд хамтран ажиллая, сургуулиас дэвшүүлсэн багш өөрийгөө тасралтгүй хөгжүүлж ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай ханган, сурагчдад сурах арга барил эзэмшүүлэх, хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, эцэг эхийн хамтын ажиллагааг өргөжүүлэх” зорилтуудыг мөрдлөг болгон дэвшүүлэн өдрөөр суралцаж буй 34 бүлэгт 1054 суралцагчтай, дүйцсэн хөтөлбөрийн 2 бүлэгт 4 сурагч, нийт 1034 сурагчид, 76 багш ажиллагсадтайгаар ажиллалаа. Энэ хичээлийн жилд 1-р ангид 110 сурагч, 9-р ангид 71 сурагч, 12-р ангид 49 сурагч суралцаж төгссөн ба бага боловсролд 558, суурь боловсролын 373, бүрэн дунд боловсрол эзэмшихээр 123 сурагч суралцаж төгссөн дараагийн ангидаа дэвшин суралцахаар боллоо.

Энэ хичээлийн жилд 1-р ангид 110 суралцагч, 5-р ангид 108 суралцагч, 9-р ангид 73, 12-р ангид 39 бүгд 1054 сурагч үүнээс бага ангид 28-42 суралцагч, дунд

ангид 24-39 суралцагч, ахлах ангид 19-30 суралцагч суралцаж, анги дүүргэлт дунджаар 32.5 байлаа. Нийт суралцагчдын малчин өрхийн хүүхэд 34.5%-ийг эзэлж байна. Төгсөх ангийн сурагчдад мэргэжил сонголтын чиглэлээр 130 сурагчдад 3-5 удаагийн сургалт сурталчилгааг хийж, 15 байгууллагатай хамтран ажиллалаа.

9-р ангиас 10-р ангид дэвшин сурагч 44, үүнээс аж ахуй дээр ажиллах-5, МСҮТ-д суралцах 20, коллежид суралцах 4 сурагч суралцахаар саналаа өглөө.

6-12 ангийн суралцагчдын монгол хэлний хичээлээр 493 сурагчаас шалгалт авахад 74.8%, математикийн хичээлээр 69.1%, суралцагч сонгох болон сургуулийн сонгох шалгалтад 74.1% -ийн амжилттай үнэлэгдлээ.

### **Хүүхэд хамгааллын чиглэлээр:**

2021-2022 оны хичээлийн жилийн ажлын төлөвлөгөө гаргаж ажилласан. Үүнд төлөвлөгөөнд тусгагдсан судалгаа бүртгэлээр

- Гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй-11
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй -11
- Дэлгэцийн донтолттой-3
- Аавтайгаа амьдардаг-11
- Ээжтэйгээ амьдардаг-69
- Тэнэмэл хүүхэд-3
- Завсардсан хүүхэд-8
- Хагас өнчин-55
- Бүтэн өнчин-2
- Тавиул хүүхэд-53
- Үрчлэгдсэн-4
- Хойд аавтайгаа амьдардаг-41
- Хойд ээжтэйгээ амьдардаг-4
- Хүнсний талонд хамрагддаг өрх-33 өрхөд 0-17 насны 93 хүүхэд байдаг.
- Дунд эрсдэлтэй-8

Нийт 18 хүүхэдтэй холбоотой кейс нээн ажиллаж байна. Сумын хамтарсан багтай хамтран ажиллаж архины хамааралтай айл өрх, хүчирхийлэлтэй айл өрх нийт 19 гэр бүлд очиж үйлчилгээ үзүүллээ. Сургуулийн сурагчдын дунд үүссэн 65 удаагийн маргаан зөрчлийг бүртгэж, тухайн үед нь арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Сургуулийн багш ажиллагсдад “Хүүхэд хамгаалал, хамтарсан баг” сэдэвт сургалтыг 03 дугаар сарын 09-ний өдөр бага сургуулийн урлаг зааланд зохион байгууллаа.



6-11-р ангийн сурагчдад “Үе тэнгийн дарамт дээрэлхэлт, гадуурхалт”сэдвээр сургалт зохион байгуулж, 368 сурагчийг хамрууллаа.



6-12-р ангийн хөвгүүдэд “Хорт зуршил” сэдвээр сургалт зохион байгууллаа.



**Дотуур байр:**

2021-2022 оны хичээлийн жилд дотуур байранд 56 өрхийн 116 хүүхэд бүртгэн хүлээн авч ажилласан байна. Үүнээс:

- 1 хүүхэд нь байранд амьдардаг-18 өрх
- 2 хүүхэд нь амьдардаг- 24 өрх
- 3 хүүхэд нь амьдардаг- 11 өрх
- 4 хүүхэд нь амьдардаг- 2 өрх
- 5 хүүхэд нь амьдардаг 1 өрх айлын хүүхдүүд хамрагдаж байна.

Дотуур байранд суралцдаг 1-5 сурагчдад зориулж “Гараа үргэлж цэвэр байлгая” хүүхэд бүрд гар угаах дараалал, ямар үед гараа угаах, гараа тогтмол угаах нь ямар ашиг тустай талаар сургалт зохион байгууллаа. Нийт 61 сурагч хамрагдлаа.

**СОЁЛ УРЛАГИЙН ТАЛААР**

Сар шинийн баярын өдрийг тохиолдуулан соёлын төвөөс бүрэн хэмжээний цахим тоглолтыг хийж гүйцэтгэн байгууллагын цахим хаягаар дамжуулан иргэд үзэгчдэд хүргэлээ.



“Үндэсний бичиг соёлын өдөр”-т тохиолдуулан “Сайхан бичигтэн” шалгаруулах тэмцээн 6-12, 8-9, 10-12 ангиудын дунд цэвэр бичигтэн шалгаруулах тэмцээн, төрийн албан хаагчид иргэдийн дунд шударга уншлагын тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 106 иргэн, сурагч оролцлоо.



Дэлхийн номын баярын өдөрт зориулж “Шинэ уншигч бүртгэх” аян зарлаж 04 дүгээр сарын 23-30-ны өдрүүдэд 67 шинэ уншигч бүртгэж, карт нээж танхимаар болон цахимаар үйлчилгээ үзүүллээ.

Цагааннуур сумын цэцэрлэг, сургуулийн сурагчид, иргэдэд орон нутаг судлах танхим өдөр бүр нээлттэй ажиллуулж байна.



Хүүхдэд бие бялдрын зөв хөгжил өгөх үүднээс бага, дунд насны нийт 30 хүүхдүүдэд өглөө өдрийн хоёр ээлжээр бүжгийн дугуйланг хичээллүүлж байна.



Тайлан гаргасан:  
ЗДТГДҮТОГүйцэтгэгч

Д.Алтанзориг

Хянасан: Засаг дарга

Ц.Баянбаатар